



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 51142

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад Өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний түүхт 25 жилийн ойг тэмдэглэх, 21 аймгийн уулзалт зөвлөгөөнийг Хэнтий аймагт 2025 оны 05 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд зохион байгуулах тул зөвлөгөөний нээлт, сургалт хийх танхим болон бусад үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зөвлөгөөнд зарцуулагдах зардал 1000000 (Нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Д.Баярцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР